



ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 11 сарын 06 өдөр

Дугаар А/608

Хэрлэн сум

“Мөнхийн хайрын урсгал” нийгэмд үйлчилдэг
төрийн бус байгууллагад дэмжлэг үзүүлэх тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Биеийн тамир, спортын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1, 8.1.7 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2 дугаар зүйлийн 2.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Мөнхийн хайрын урсгал нийгэмд үйлчилдэг Төрийн бус байгууллагаас ирүүлсэн хүсэлтийн дагуу Монгол улсын Ерөнхийлөгчийн “Эрүүл Монгол хүн” үндэсний хөдөлгөөн, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.3.1.1.3, 2.1.4.1.2 заалтуудыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд “Идэвхтэй хөдөлгөөн—Эрүүл Хэнтийчүүд” аяныг зохион байгуулахад 2,000,000 (хоёр сая) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2.Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын нөөц сангийн байгууллага, иргэдээс тавьсан санал хүсэлтийг шийдвэрлэх зардлаас санхүүжүүлэхийг Засаг даргын Тамгын газрын дарга (А.Жаргалсайхан), аймгийн Засаг даргын тамгын газрын нягтлан бодогч (Ж.Ариунтунгалаг) нарт зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Б.Өнөрцолмон) -д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Д.АЮУРБУНЬ

